Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

# Анхдугаар ТАВАН ЖИЛ

Төв аймгийн намын хороо, А. Д. Х. Гүйцэтгэх захиргааны сонин.

22 дахь жилдээ № 83 (1867) | 1969 оны 11 дүгаар сарын 3 | ДАВАА

*Октябрийн социалист их хувьсгалын үзэл санааны туг, империализмын эсрэг, социализм, коммунизмын ялалтын төлөө орон бүхний хөдөлмөрчдийн тэмцлийн замыг заагч од болсон аугаа их интернационалист сургаал марксизм—ленинизм мандтугай.*

(МАХН—ЫН ТӨВ ХОРООНООС АУГАА ИХ ОКТЯБРИЙН СОЦИАЛИСТ ХУВЬСГАЛЫН 52 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛАН ГАРГАСАН УРИАНААС)

## В. И. ЛЕНИН БА ТЭРГҮҮН ТУРШЛАГА

Нийгмийн шинэ байгуулал ялахад хамгийн чухал, хамгийн гол зүйл бол эцсийн дүнд хөдөлмөрийн бүтээмж болохыг В. И. Ленин онцлон заахын зэрэгцээгээр шинэ санаачлага, тэргүүн туршлагын асар их ач холбогдолтойг өөрийн удаа дараагийн бүтээлүүдэд тодорхойлон заасан байдаг. Марксизм—Ленинизмийн сургаалаар удирдлага болгосон МАХН нь эх орондоо социализм бүрэн төгс байгуулан дуусгах үйл хэрэгт манай ажлын салбар бүрт шинэ санаачлага тэргүүн туршлагыг улам бүр өрнүүлэн хөгжүүлж түүнийг дэмжин дэлгэрүүлж үйлдвэрлэлд нэвтрүүлж байхыг нам, улс, орон нутгийн байгууллагуудад онцлон заасаар ирлээ.

Шинжлэх ухааны ололтыг ашиглан, тэргүүн туршлага, шинэ санаачлагыг тухай бүрд нь дэмжиж дэлгэрүүлэх замаар олон түмний идэвх хөдөлгөөнийг өрнүүлэх нь дээрх зорилтыг биелүүлэхэд чухал ач холбогдолтой болно.

МАХН—ын программ ба МАХН—ын Төв Хорооны V бүгд хурлын шийдвэрт дотоодынхоо бүх нөөц бололцоог дээд хэмжээгээр дайчлахыг маш чухал зорилт болгон тавьжээ.

Ийм ч учраас сүүлийн жилүүдэд МАХН—ын Төв Хорооноос „Хөдөө аж ахуйд тэргүүн туршлага нэвтрүүлэх“ мөн „Шинэ санаачлага, тэргүүн туршлага сурталчлах ажлыг сайжруулах тухай“ чухал чухал тогтоол шийдвэрүүдийг гаргав.

Тус аймгийн нам, улсын байгуулллагууд үйлдвэр, ялангуяа хөдөө аж ахуйд шинэ санаачлага, тэргүүн туршлага нэвтрүүлэх ажлыг зохиохдоо юуны өмнө үйлдвэрлэлийн тэргүүний сайчуул, аврагуудыг шалгаруулан түүний арга барилыг нийтэд эзэмшүүлэх ажлыг зохиох, хөдөлмөрийн баатрууд аврагуудыг томилолт ба илгээлтээр ажиллуулах, тэргүүн туршлагын ба үзүүлэн сургуулиудыг үе үе зохион явуулах зэргээр ажиллаж байна.

Жаргалант, Баянцогт, Батсүмбэр, Өнжүүл, Баянзүрх зэрэг олон сумдын нам, улсын байгууллагуудаас тэргүүн туршлагыг судлаж олох, сурталчилж эзэмшүүлэх ажлыг бүтээлчээр зохион байгуулдаг нь үйлдвэрлэлд зохих үр дүнгээ өгч байгаа юм.

Гэвч тэргүүн туршлагыг удирдлагын арга барилын салшгүй хэсэг болгон тогтмол анхаарч ажиллах явдал газар бүрт жигд сайнгүй байна.

Энэ нь юуны өмнө САА, ХАА нэгдэл тус бүр өөртөө байгаа туршлага ололтоо олж бүртгэн түүнийгээ бусдад нь эзэмшүүлэн ажиллах явдал хангалтгүй байгаагаас тодорхой байна.

Жил тутмын тэргүүн туршлага нэвтрүүлэх төлөвлөгөө гэгч хэдхэн зүйлийн нэрийн жагсаалтыг ямарч тооцоо, судалгаа ба туршиж, эзэмших эзэнгүйгээр баталж гаргасан төдийхнөөр ажлаа хязгаарлаж байгаа нь маш хангалтгүй хэрэг мөн.

Ийм учраас В. И. Ленинии мэндэлсний алдарт зуун жилийн ойг угтаж байгууллага, аж ахуйн салбар бүхэн өөртөө байгаа тэргүүн туршлагаа бүртгэн дүгнэж юуг нь бүрэн эзэмшиж нэвтэрсэн, юуг нь цаашид туршин сорих ба үйлдвэрлэлд нэвтрүүлэхээ тодорхой судлан дүгнэж зааглан түүнийг эзэмших эзэн, түүнд шаардагдах хөрөнгийг шийдвэрлэн өгч тодорхой болгосон байх хэрэгтэй. 12 дугаар сарын эцсээр болох аймгийн намын ээлжит бүгд хурлаар Ленин ба тэргүүн туршлагын тухай авч хэлэлцэх гэж байгаа учир аймгийн хэмжээгээр тус бүгд хурлыг угтаж 1969 оны аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтуудын дутуүг гүйцээх ялангуяа сум бүр мал өсгөх төлөвлөгөөг биелүүлсэн дүнтэйгээр угтах хэрэгтэй.

Нэгдэлжих хөдөлгөөн ялсны 10 жилийн ойн өмнө

## АВРАГА СААЛЬЧИН

Баянцагаан сумын «Өрнөх—амьдрал» нэгдлийн нэгдүгээр бригадын саальчин Юудэнгийн Мажиг сүүлийн 5 жил дараалан «Аврага саальчин» алдрыг хадгалж явна.

н. Мажиг сүү саалийн ажилдаа БНМАУ—ын хөдөлмөрийн баатар, саальчин Авирмэдийн туршлагыг хэрэглэж байна.

Энэ жил 15 үнээ сааж жилийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 15 хоногийн өмнө 110 хувиар биелүүлж, нэгдэлжих хөдөлгөөн ялсны 10 жилийн ойдоо хөдөлмөрийн өндөр амжилтаар бэлэг барив.

Саальчин Мажиг ярихдаа:

—Хариуцсан үнээндээ дээд зэргийн тарга хүч авахуулж хээлийг нь сайн хамгаалан, гарсан тугалаа бүрэн бойжуулах нь чухал байдаг.

Иймд хашаа хэвтрийн хувьд тун сайн анхаардаг. Бас давчуу хашаанд хэт олон үхэр хаших нь хээл гэмтэх нэг шалтгаан болдог байна.

Мөн хээлтэй үнээг хээлийн хугацааны хоёрдугаар хагасаас эхлэн нэмэгдэл тэжээлээр тэжээдэг. Ингэж тэжээж байсан үхрийн тугалын өсөлт торинолт хурдан, өвчин эмгэгт нэрвэгдэх нь бага байдаг. Энэ саальчин нялх тугалд эхийн уургийг цадтал хөхүүлж даарuulахгүй байхыг хичээдэг аж.

Ер нь нялх тугал нойтон хэвтэр, чийг зэргээс болж чацга алдах нь их байдгийг анхаарч, хэвтрийг үргэлж хуурай байлгах, зуны халуунд тугалыг наранд удаан байлгавал наршиж нарны хордлого болдог учир зун тугалаа нар бороонoос хамгаалах сүүдэр барьж өгдөг байна.

—Мажиг цааш ярихдаа: Их сүү саахын нэг үндэс бол саальчин хүн үнээ бүрийнхээ зан төрх, сүүний гарц дэлэн хөхний хатуу, зөөлөн зэргийг сайн мэддэг байхаас гадна шинээр нэмэгдэж байгаа гунжин үнээний дэлэн хөхийг сайн илж шувтарч байх нь их сүүтэй болгохын нэг үндэс болдог.

Саальчин хүн үнээ бүрийг өөртөө сайн дасгахаас гадна аль болохоор тайван байлгаж саах нь чухал.

—Үнээг саахдаа байнга дэс дараалалтай сааж зан шуулбал саах хугацаагаа болохоор сүүг дэлэндээ бүрэн хуримтуулж саахад тайван байж сүүгээ бүрэн өгдөг.

—Саальчин хүн эхлээд тогтвор муутай догшивтор болон хатуу хөхтэй, олон ивэлгэдэг үнээг сааж, сүүлд нь зан сайтай үнээгээ саах нь ашигтай гэж зөвлөн ярьж байна.

**Н. Нанжид**
**Д. Дамдинсүрэн**

## ИХ ОЙГ УГТАЖ...

В. И. Лениний мэндэлсний 100 жилийн ойг угтаж Эрдэнэ сумын дунд сургууль бүх анги танхимд Лениний үйл амьдралаар булан байгууллаа

Мөн 7 хоног бүрийн Ням гаригт Лениний үйл амьдралаар хөдөлмөрчдөд ухуулга хийж байна.

## Соёлжилтын үзлэг явуулав

Эрдэнэ сумын эмэгтэйчүүдийн зөвлөл, хүний их эмчийн салбартай хамтран сумын төвийн бүх айл өрхийн ариун цэвэр, соёлжилтонд үзлэг явуулав. Үзлэгт 80 гаруй айл орж нийт айлууд сайн бэлтгэсний дотроос Сүхээ, Бадарч, Цэрэнбадам зэрэг айлуудын соёлжилт гоц сайн байв.

**Ц. Доржсүрэн**

## ГАВШГАЙЧИД

Алтанбулаг сумын «Хөдөлмөр» нэгдлийн Социалист хөдөлмөрийн бригадын гишүүн Чойжил, Бямбаа, Сэрдамба, Гомбо, Намсрай, Цэдэш нар социалист хөдөлмөрийн бригадын гавшгайчдын улсын зөвлөлгөөн, нэгдэлжих хөдөлгөөн ялсны 10 жилийн ойг угтаж нэгдэлдээ 16 ортой зочид буудал барьж 10 дугаар сарын 20-нд хүлээлгэж өгөв.

**Б. Лувсан**

## СПАРТАКИАД БОЛОВ

Өнжүүл сумын 8 жилийн дунд сургуулийн намрын спартакиадыг 4 төрөлт ба 400, 800 метрийн гүйлтийн төрлүүдээр зохион явуулав. Спартакиадад ангиудаас шалгарсан аврагууд оролцон сургуулийн аврагын төлөө тэмцэлдэж 7-ын «А» ангийн сурагч Дариймаа, 8-ын «А» ангийн сурагч Даваадорж, 4-ийн «А» ангийн сурагч Дуламсүрэн, 4-ийн «Б» ангийн сурагч Пүрэвжав нар 4 төрөлтийн бага дунд ангийн аврага болсноос гадна 400, 800 метрийн гүйлтэнд 8-ын «А» ангийн сурагч Оюунгэрэл, Цэндээхүү нар аврага боллоо.

Мөн 4-ийн «А» ба 8-ын «А» ангиуд сургуулийн спортын аврага анги болов.

* * *

Тус сумын 8 жилийн дунд сургуулийн 7-гийн «Б» ангийн хамт олон Монгол—Зөвлөлтийн найрамдлын сарын ажлыг тохиолдуулан „Мөнх найрамдал“ гэсэн сэдэвт үдэшлэг зохиосон нь олны сонирхлыг татлаа.

**Ц. Дашиймаа**

